



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/114

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Амьтны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий агнуур зохион байгуулалтыг аймгийн нутаг дэвсгэрт хийж, ан амьтны тархац нутаг, нөөц, агнуурын амьтны нас, хүйсний бүтэц, нөхөн үржлийн чадавхийг судалсны үндсэн дээр агнуурын бүс нутгийн хилийн зааг, хэмжээг тогтоож, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах зардалд зориулан 50,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 50,000,000 төгрөг /тавин сая/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 4.8-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчлигээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 07 8889

Zah A/114 Kh